

## ШАРГА СУМД 2018 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2018.01.25

Баянгол

### ШАРГА СУМД ӨВӨЛЖИЛТИЙН БАЙДАЛ ХҮНДЭРЧ БАЙНА

Аймгийн засаг дарга С.Гансэлэм, ЗДТГ-ын дарга Ч.Бат-Эрдэнэ нар сумын мал аж ахуйн өвөлжилтийн нөхцөл байдалтай ирж танилцлаа. Өвөлжилт хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа Шарга сумд аймгийн нөөцөөс 540 боодол өвс гаргаж малчдад тараалаа. Шарга сум зундаа газрын гарц тааруу байсан учраас өвөлжилт хүндэрч өнөөгийн байдлаар бүх багийн нутгаар цасан бүрхүүл тогтсон цасны зузаан уулархаг нутгаараа 10-15см цастай, хүйтний эрч өдөртөө 30-35 градус шөнөдөө 35-45 градусын хүйтэнтэй байгаа нь бүх багт мал сүргийн өвөлжилтийн байдал хүндрээд байна. Шарга сумд одоогийн байдлаар 1500 орчим тоо толгой мал хорогдсон дүн



мэдээтэй байна. Хөдөө багийн зарим малчидтай холбоо барьж чадахгүй байгаа нь малын хорогдлын мэдээ нарийн гарахад бэрхшээлтэй байгаа.

Энэ сарын 10-14-ний өдрүүдэд Алтай, Бугат, Төгрөг сумд өвөлжиж байгаа малчдаа эргэлээ. Сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг 2 чиглэлд гарч малчиддаа хүрч, өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, ард иргэдийнхээ санал хүсэлтийг сонсох, тэдэнд хүн, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх, хүндэрч байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэхээр ажиллаж байна.

Сумын удирдлагаас төрийн албан хаагчид малчдад туслах аяныг өрнүүлж төсөвт байгууллагуудыг багуудтай хамтын холбоо тогтоож ажиллахаар шийдвэрлэлээ.

- Хамтын хүч багийн малчдад -ИТХ, ЗДТГ-ын ажилтнууд
- Сондуулт багийн малчдад-ЭМТ-ийн ажилтнууд
- Улаантуг багийн малчдад-Цэцэрлэг, Соёлын төвийн ажилтнууд
- Баянгол багийн малчдад-Сургуулийн ажилтнууд хандив цуглуулж туслахаар хөдөлгөөн өрнүүлж байна.



Мөн сумын Залуучуудын холбооноос “Малчиддаа тусалъя” хандивын тоглолтыг энэ сарын 26-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.

### **БӨХӨН ЗЭЭРЭНД ӨВС ТЭЖЭЭЛ ТАВЬЖ ӨГЛӨӨ**

Цаг агаар, өвөлжилт хүндэрч байгаа Шаргын говь, Хүйсийн говьд байгаа бөхөн, хар сүүлтэй, цагаан зээр зэрэг амьтаддаа БОАЖГ, ДБХС хамтран өвс, тэжээл, хужир тавьж биотехникийн арга хэмжээг эхлүүллээ. Мөн хяналтын камерыг суурилууллаа.



### **МЭДЭЭЛЛИЙН ЦАГИЙГ ХИЙЛЭЭ**

Засгийн газрын тогтоолын дагаа 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг мэдээллийн цагийг энэ сарын 2, 15, 22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Мэдээллийн цагаар сумын удирдлагууд цаг үеийн ажил танилцуулж үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн Төрийн сангийн мэргэжилтэн, Улсын бүртгэгч нар статистик мэдээг танилцуулсан. Мэдээллийн албан байгууллагуудын дарга эрхлэгч нар, ЗДТГ-ын мэргэжилтнүүд, цагдаа, хэсгийн төлөөлөгч, эрчим хүчний салбарын эрхлэгч нар хамрагддаг.

Мэдээлэл бэлтгэсэн: Д.Ончимэг